

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД 2009 ОНД УЛААНБААТАР ХОТООС ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. МУИС 2009-2010 оны хичээлийн жилд бакалаврын зэрэг олгох сургалтад Улаанбаатар хотоос оюутан элсүүлэхэд “Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам” (БСШУ-ы сайдын 2005/422, 2006/483 тушаалаар баталсан) болон энэхүү журмыг баримтлана.
2. Аймаг орон нутгаас элсэхийг хүсэгчдийг бүртгэх, мэргэжил сонгуулах ажлыг Их, дээд сургуулиудын элсэлтийн дундын комисс тухайн аймагт нь зохион байгуулна. Аймагас оюутан элсүүлэх нэгдсэн журмыг тусгайлан гаргаж, нийтэд мэдээлнэ.

Хоёр. Зохион байгуулалт

1. Оюутан элсүүлэх ажлыг хоёр үе шаттай зохион байгуулна. Эхний шатанд: МУИС-д элсэх хүсэлтэй иргэн энэхүү журмын 7-д заасан Ерөнхий шалгалт (ЕШ) өгнө. Хоёр дахь шатанд: ЕШ өгч, энэхүү журмын 9 ба 12-т заасан болзлыг хангасан иргэний өргөдлийг МУИС-ийн элсэлтийн комисс хүлээн авч, зохих хяналтын тоонд багтаан шалгаруулалт хийнэ.
2. Элсэгчдийн сурах ерөнхий чадвар, мэдлэгийн төвшин тогтоох зорилго бүхий ЕШ-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас эрх олгосон хөндлөнгийн байгууллага зохион байгуулах бөгөөд шалгалтын асуулт боловсруулах, олшруулах, нууцлалыг хадгалах, зохион байгуулах, оноог иргэд болон сургуульд хүргэх, шалгалттай холбоотой иргэдийн гомдол хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, бүхий л мэдээллээр хангах үүргийг энэхүү байгууллага хүлээнэ.
3. Энэхүү журам болон элсэлтийн ажлын зохион байгуулалттай холбоотой нэмэлт мэдээллийг МУИС-ийн вэб хуудас www.num.edu.mn/admission/ болон Боловсролын үнэлгээний төвийн www.eec.mn сайтад байрлуулна.
4. Урьд нь дээд болон тусгай дунд боловсрол эзэмшсэн иргэнийг зарим мэргэжлээр бакалаврын зэрэг олгох сургалтад орой ба эчнээ хэлбэрээр суралцуулна. Үүнд:
 - Оройн ангид: дээд боловсролтой (бакалавраас дээш) иргэнийг эрх зүй, ня-бо, санхүү, аялал жуулчлалын менежмент, англи хэлний багш, геологийн мэргэжлээр;
 - Эрх зүйн эчнээ ангид: дээд боловсролтой иргэнийг, 2009 оны 3-р сард;
 - Ня-бо, статистик, хүн ам зүйн эчнээ ангид: дээд боловсролтой иргэнийг элсүүлнэ.

Эдгээр ангид элсэгчдээс ЕШ өгөхийг шаардахгүй бөгөөд элсэлтийг энд хавсаргасан “МУИС-ийн орой, эчнээ сургалтанд оюутан элсүүлэх журам” -аар тусад нь зохион байгуулна.

5. Энэ журмын 4-т зааснаас бусад чиглэлээр хоёр дахь дээд боловсрол эзэмших хүсэлтэй бол энэхүү журмын дагуу ЕШ өгч элсэх бөгөөд элссэнийхээ дараа өмнөх дээд боловсрол эзэмшихдээ үзсэн хичээлүүдийн кредитийг тооцуулах замаар товчлон суралцах боломжтой .

Гурав. Элсэгчдэд тавих шаардлага ба шалгалт

- a. МУИС-д элсэгч бүрэн дундаас доошгүй боловсрол эзэмшсэн байна.
6. МУИС-ийн аль сургууль/факультетэд ямар мэргэжлийн чиглэлээр (бүлгээр) элсэхэд ямар хичээлийн ЕШ өгсөн байхыг Хавсралтад заав.
7. Мөн зарим мэргэжлийн онцлогоос хамаарч энэхүү журмын 18-д зааснаар авъяас чадварыг тогтоох нэмэлт шалгалт авна.
8. Шалгалтад авбал зохих нийт онооны 60%-ийг авбал МУИС-д элсэх болзол хангасан гэж үзэх бөгөөд шалгалтад авсан нийт оноог дараах байдлаар тодорхойно. Үүнд:
 - a. Тухайн бүлгээр ганц шалгалт авахаар байгаа бол уг шалгалтад авсан оноо;
 - b. Тухайн бүлгээр хоёр шалгалт авах бол хоёр шалгалтын оноог 70:30 харьцаагаар нэмж, өөрөөр хэлбэл, I шалгалтад авсан оноог 0.7-оор, II шалгалтад авсан оноог 0.3-аар үржүүлж нэмнэ;

- c. Нэмэлт шалгалттай тохиолдолд: компьютер/график дизайны мэргэжлээр элсэгчдийн хар зураг, урлаг судлалаар элсэгчдийн авъяас чадварын оноо нь нийт оноонд 30 хувь, харгалзах ерөнхий шалгалтын (хавсралтад заасан) оноо 70 хувийг эзэлнэ; сэтгүүл зүйн мэргэжлээр элсэгчдийн бичлэгийн ур чадвар, монгол хэл, гадаад хэлний шалгалтуудын оноог 30:40:30 харьцаагаар нэмнэ.

Дөрөв. Бүртгүүлэх

9. МУИС-д өдрийн ангид Улаанбаатараас элсэхийг хүсэгчдийн бүртгэл (11-д заасан холбогдох материалыг авчирна) 2009 оны VII/1-4- ний өдрүүдэд МУИС дээр явагдана. VII/6-нд мэргэжил сонгуулна. Элсэлтийн комиссын хаяг, бүртгэл явагдах байр болон мэргэжил сонгуулах хуваарь, нэмэлт мэдээллийг VI/25-нд МУИС-ийн төв байрны гадна болон www.num.edu.mn вэб-д тавина.
- Мэргэжил сонгуулахаар зарласан хуваарьт өдөр/цагт ирээгүй хүнийг өөр сургууль/мэргэжил сонгосон гэж үзэж дараагийн хүнд нь сонголтыг шилжүүлнэ.
10. Бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:
- a. Боловсролын гэрчилгээний хуулбар (нотариатаар батлуулах албагүй)
 - b. Ерөнхий шалгалтын батламж, хуулбарын хамт
 - c. Цээж зураг 2 хувь (2009 оны)
 - d. Бүртгэлийн хураамж 3000 төгрөг.
11. МУИС-д “элсэх болзол хангасан” иргэн элсэх өргөдөл өгөх эрхтэй боловч элсэх боломж нь хяналтын тоо, тухайн мэргэжлээр элсэхийг хүсэгчдийн өрсөлдөөний байдлаар хязгаарлагдана. Иймд өргөдөл ирүүлэх хүний тоонд хязгаар тогтооно:
- a. Элсэлтийн бүлэг бүрээс бүртгүүлэгчийн тоо Хавсралт дахь бүлэг бүрийн ард заасан тоогоор хязгаарлагдана. Энэ тоо нь 1-р хичээлийн шалгалтын оноогоор Улаанбаатарын хэмжээнд эзэлсэн байр бөгөөд энэ байранд байгаа шалгуулагчтай ижил оноотой бүх хүнийг тухайн байранд багтсан гэж үзнэ. ЕШ-ын оноогоороо энэ байранд багтсан хүмүүсийг бүртгэнэ. (Жишээ нь: МКС-д математикийн чиглэлээр буюу 1-р бүлгийн 5 мэргэжлийн аль нэгэнд элсэхийг хүсвэл математикийн шалгалтын оноогоор эхний 600-д багтсан хүнээс дутуугүй оноотой байх шаардлагатай. Хавсралтын доорхи тайлбарыг үзнэ үү.)
 - b. Иргэн МУИС-д хэд хэдэн мэргэжлийн бүлгээр элсэхээр бүртгүүлж болно. Хэрэв энэ бүлгүүд нь өөр өөр сургууль/факультет-д (эдгээр 12 нэгжийг Хавсралтаас үз) харьяалагдаж буй бол тус тусад нь бүртгүүлэх шаардлагатай.

Тав. Оюутан элсүүлэх шалгаруулалт

12. МУИС-д нийслэл болон аймгуудаас элсүүлэх оюутны тоог (хяналтын тоо) БСШУЯ тогтооно.
13. Шалгуулагчдыг Хавсралтад заасан 22 мэргэжлийн бүлэг болгон шалгалтын нийт оноогоор (энэхүү журмын 9-д заасан аргачлалаар тодорхойлсон) жагсааж, онооны дарааллаар батлагдсан хяналтын тоонд багтаан элсүүлнэ.
14. Шалгалтын оноо тэнцсэн тохиолдолд боловсролын үнэмлэхэд бичигдсэн хичээлүүдийн дүнгийн дундажийг харьцуулан шийдвэрлэнэ.
15. Улаанбаатараас оюутан элсүүлэх хуваарь дээр нийслэд оршин суугаа иргэн өрсөлдөх эрхтэй ба нэг бүлгээс нөгөөд шилжүүлэн элсүүлэхгүй.
16. Зохих хяналтын тоонд багтсан хүмүүст суралцах эрхийн бичиг олгоно.

Зургаа. Нэмэлт шалгалт

17. Тодорхой авъяас шаардах мэргэжлээр элсэх хүмүүсээс ур чадварын нэмэлт шалгалт авна. Үүнд: компьютер/график дизайны мэргэжлээр элсэгчдээс хар зураг, сэтгүүл зүйн мэргэжлээр элсэгчдээс бичлэгийн ур чадвар, урлаг судлалын чиглэлээр элсэгчдээс мэргэжлийн ур чадварын (эссе бичүүлэх) нэмэлт шалгалт авна. Нэмэлт шалгалт авах хуваарийг бүртгэх үед зарлана.

Долоо. Хөнгөлөлттэй нөхцлөөр элсүүлэх

18. 2009 оны улсын олимпиадад 1-3-р байр эзэлсэн, олон улсын олимпиадад шагналт байранд шалгарсан сурагч тухайн чиглэлээр элсэхийг хүсвэл шууд элсүүлнэ.
19. 2009 оны улсын олимпиадад байгалийн ухааны чиглэлээр оролцсон сурагч тухайн мэргэжлээр элсэхийг хүсвэл энэ журмын 9-д зааснаар “элсэх болзол хангасан” нөхцөлд онооны дараалал харгалзахгүй элсүүлнэ.
20. МУИС-ийн харъяа Байгалийн ухааны төрөлжүүлэн гүнзгийрүүлсэн сургалттай ахлах сургуулийн төгсөгч уг мэргэжлийн чиглэлээр элсэх бол мөн “элсэх болзол хангасан” нөхцөлд онооны дараалал харгалзахгүй элсүүлнэ.
21. Энэ журмын 19-21-т заасан хөнгөлөлттэй нөхцлөөр элссэн хүн элссэнийхээ дараа мэргэжил сольж суралцахыг зөвшөөрөхгүй.

Найм. Элсэгчдийг бүртгэх

22. Элссэн хүмүүс 2009 оны 8-р сарын 24-28-нд МУИС дээр бүртгүүлнэ. Дурьдсан хугацаанд бүртгүүлээгүй хүнийг сургууль орхисонд тооцож хасна.
23. Элссэн хүмүүс бүртгүүлэхдээ дараах баримт бичгүүдийг бүрдүүлсэн байвал зохино. Үүнд:
 1. Бүрэн дунд боловсролын үнэмлэх буюу түүнтэй адилтгах бичиг баримт
 2. ЕШ-ын дүнгийн тодорхойлолт
 3. Сурагчийн хувийн хэрэг (ажиллагсад нийгмийн даатгалын дэвтэр)
 4. Сургуулийн тодорхойлолт (2008, 2009 онд ЕБДС төгсөгчдөд хамаарна.)
 5. Иргэний үнэмлэх
 6. Цээж зураг 6 хувь
 7. Сургалтын төлбөр төлсөн баримт (Зээл авах, төрөөс хариуцах бол холбогдох бичиг баримтууд; Төрийн албаны тухай хуулийн дагуу төлөгдөх бол эцэг эхийн аль нэгний албан газартай хийсэн гэрээ)Эдгээр материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.
24. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн хүнийг МУИС-д элсүүлэхгүй, элссэн тохиолдолд хасна.

МУИС-ийн Элсэлтийн Комисс

Утас: 320892, 318161

Бүрэлдэхүүний факультет/сургуулийн утас:

Математик, компьютерийн сургууль (МКС)	311443, 325631
Физик, электроникийн сургууль (ФЭС)	327330, 329993
Мэдээллийн технологийн сургууль (МТС)	324007, 325305
Химийн факультет (ХФ)	327793, 322278
Биологийн факультет (БФ)	323970, 322608
Газар зүй, геологийн факультет (ГГФ)	311809, 322822
Монгол хэл, соёлын сургууль (МХСС)	314327, 325435
Гадаад хэл, соёлын сургууль (ГХСС)	326305, 322897
Нийгмийн шинжлэх ухааны сургууль (НШУС)	319392, 328890
Хууль зүйн сургууль (ХЗС)	327745, 321739
Эдийн засгийн сургууль (ЭЗС)	350277, 350994
Олон Улсын Харилцааны Сургууль (ОУХС)	354618, 354610

ХАВСРАЛТ

МУИС, түүний бүрэлдэхүүний факультет/сургуулиудад оюутан элсүүлэх мэргэжлийн бүлэг, хүлээж авах өргөдлийн тоо, өгсөн байх ерөнхий шалгалт, нийт оноонд эзлэх харьцаа

Фак, Сур.	Бү	Мэргэжил	Байр ⁶⁾	I - 70%	II - 30%
МКС	1	Математик; математик-мэдээлэл зүйн багш; хэрэглээний математик; хэрэглээний статистик; эдийн засгийн математик загварчлал	600	Математик	
	2	Мэдээллийн систем; мэдээллийн системийн менежмент; программ хангамж	300		
МТС	3	компьютерийн техник; компьютерийн техник хангамж/сүлжээ; компьютерийн программ хангамж;	450	Математик	
	4	компьютер/график дизайн ^{в)}	450	Математик	
	5	Электроник/автоматик; мультимедиа холбооны технологи	450	Математик	Физик
ФЭС	6	Физик; цөмийн технологи; физик-электроник; физик-байгалийн шинжлэлийн багш; геофизик; хэрэглээний геофизик; сэргээгдэх эрчим хүч	400	Физик	
ХФ	7	Хими; хими технологи; нефтийн хими; экологийн хими; хүнсний хими; эрдэс материалын хими; байгалийн нэгдлийн хими; хими-байгалийн шинжлэлийн багш	850	Хими	Физик/биологи
БФ	8	Биологи; экологи-байгаль хамгаалал; биотехнологи; ойн инженер; байгалийн аялал жуулчлал; Биоинформатик*	600	Биологи	Математик
ГГФ	9	Газарзүй; газар зохион байгуулалт; үйлдвэрлэлийн менежмент (аялал жуулчлалын менежмент, уул уурхайн менежмент); эдэлбэр газрын кадастр/зураглал; байгаль хамгаалал ба хяналт үнэлгээ; хөрс судлал; Хот ба бүс нутаг төлөвлөлт*	600	Математик	Газарзүй
	10	Геологи; шатах ашигт малтмалын эрэл хайгуул; уул уурхайн менежмент	1000		
	11	Хүрээлэн байгаа орчны хамгаалал; цаг уур; ус судлал	900	Математик	Физик
МХС С	12	Монгол хэл/уран зохиол; эх бичиг судлал; утга зохиол судлал/шүүмж	700	Монгол хэл	
	13	Урлаг судлал ^{в)}	900		
	14	Монгол-гадаад хэл/судлал: Монгол-Англи; Монгол-Хятад; Монгол-Япон	500	Монгол хэл	Англи/орос хэл
ГХСС	15	Гадаад хэл/орон судлал: Англи-Америк; герман; франц; орос; польш; хятад;	600	Англи/орос хэл	

		япон; солонгос; турк			
НШУ С	16	Сэтгүүл зүй ба олон улсын сэтгүүл зүй ^{в)}	350	Монгол хэл	Англи/орос хэл
	17	Түүх; антропологи; археологи; угсаатны зүй	1000	Монгол улсын түүх	
	18	Социологи; гүн ухаан; шашин судлал; улс төр судлал; сэтгэл судлал; нийгмийн ажил	1000	Нийгмийн тухай мэдлэг	Англи/орос хэл
ХЗС	19	Эрх зүй ба олон улсын эрх зүй	400	Нийгмийн тухай мэдлэг	Математик
ЭЗС	20	Нягтлан бодох бүртгэл; банкны менежмент; санхүүгийн менежмент (даатгал, санхүү/мэдээлэл зүй); санхүү-эдийн засаг; татварын ня-бо хяналт; олон улсын худалдааны менежмент; маркетингийн менежмент; бизнесийн менежмент; эдийн засаг/статистик; хүн ам зүй; эдийн засгийн онол ба олон улсын эдийн засаг	300	Математик	
ОУХС	21	Олон улсын харилцаа	300	Англи хэл	Монгол улсын түүх
	22	Олон улсын эдийн засгийн харилцаа	300	Математик	Англи хэл

Тайлбар:

^{а)} Факультет/сургуулийн бүтэн нэрийг энэхүү журмын төгсгөлөөс үз.

^{б)} Энэ тоо нь 1-р хичээлийн шалгалтын оноогоор Улаанбаатар хотын хэмжээнд эзэлсэн “байр” бөгөөд энэ “байранд багтсан” хүний өргөдлийг МУИС хүлээж авна. Энд заасан байранд байгаа шалгуулагчтай ижил оноотой бүх хүнийг тухайн байранд багтсан гэж үзнэ. Жишээлбэл:

- Улаанбаатарт математикийн онооны жагсаалтын 290-р байранд байгаа бол 1, 2, 3, 4, 6, 9, 10, 19, 21 дүгээр бүлгээр, 660-р байранд байгаа бол зөвхөн 6, 10 дугаар бүлгээр элсэхээр өргөдлөө өгөх боломжтой юм.
- Мөн жагсаалтын 283-аас 318-р байранд байгаа бүх шалгуулагч ижилхэн 685 оноо авсан гэж үзвэл энэ 36 хүнийг бүгдээрээ 300-р байранд багтсан гэж үзнэ.

^{в)} Энд заасан ЕШ-аас гадна нэмэлт шалгалт өгнө (Энэ журмын 9, 18-р заалтыг үз.).

* Шинэ мэргэжил

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ОРОЙ, ЭЧНЭЭ СУРГАЛТАД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Урьд нь дээд болон тусгай дунд боловсрол эзэмшсэн иргэнийг зарим мэргэжлээр МУИС-ийн орой, эчнээ хэлбэрээр бакалаврын зэрэг олгох сургалтад элсүүлэхэд “Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам” (БСШУ-ны сайдын 2005/422, 2006/483 тушаалаар баталсан) болон энэхүү журмыг баримтлана
2. Орой, эчнээ сургалтын элсэгчдийг бүртгэх, элсэлтийн шалгалт зохион байгуулах асуудлыг элсэлтийн комисс эрхлэн гүйцэтгэнэ. Элсэлт авах тухай зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана
3. Орой, эчнээ сургалт явуулах мэргэжлийг сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд зааснаар тогтооно. Оройн сургалтын хичээлийн жил 9 дүгээр сарын 1-ний өдөр эхэлнэ
4. Энэхүү дүрэм, элсэлтийн ажлын зохион байгуулалттай холбоотой нэмэлт мэдээллийг МУИС-ийн вэб хуудас www.num.edu.mn/admission/ болон тухайн бүрэлдэхүүний сургуулийн вэб сайтад байрлуулна

Хоёр . Элсэгчдэд тавих шаардлага ба шалгалт

5. Эчнээ ангид (эрх зүй, ня-бо, статистик, хүн ам зүй, цаг уур) дээд боловсролтой эсвэл тухайн мэргэжлээр тусгай дунд боловсролтой иргэнийг элсүүлнэ. (элсүүлэх мэргэжлийг тухайн жилд зарлана)
6. Оройн ангид (эрх зүй, ня-бо, санхүү, аялал жуулчлалын менежмент, англи хэлний багш, мэдээллийн технологи, геологи) бакалавраас дээш боловсролтой иргэнийг элсүүлнэ.
7. Энэ журмын 5, 6-д зааснаас бусад чиглэлээр хоёр дахь дээд боловсрол эзэмших хүсэлтэй иргэн Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх журмын дагуу ЕШ өгч элсэх бөгөөд элссэний дараа өмнөх дээд боловсрол эзэмшихдээ үзсэн хичээлүүдийн багц цагийг тооцуулах замаар товчлон суралцах боломжтой.
8. Төрийн өндөр албан тушаалтныг эрх зүйн мэргэжлээр элсэлтийн шалгалтгүй шууд элсүүлэх асуудлыг МУИС-ийн захирлын зөвшөөрлөөр тусгайлан шийдэж болно
9. Орой, эчнээ ангид элсэх хүсэлтэй иргэн энэ журмын хавсралтад заасан шалгалт өгнө
10. Шалгалтад авбал зохих нийт онооны 60%-ийг авбал МУИС-д элсэх болзол хангасан гэж үзэх бөгөөд шалгалтад авсан нийт оноог дараах байдлаар тодорхойно. Үүнд:
 - a. Тухайн бүлгээр нэг шалгалт авахаар байгаа бол уг шалгалтад авсан оноо;
 - b. Тухайн бүлгээр хоёр шалгалт авах бол хоёр шалгалтын оноог 70:30 харьцаагаар тооцно. Өөрөөр хэлбэл, I шалгалтад авсан оноог 0.7-оор, II шалгалтад авсан оноог 0.3-аар үржүүлж нэмнэ.

Гурав. Өргөдөл хүлээж авах

11. МУИС-ийн оройн ангийн элсэлтийг тухайн оны 6 дугаар сард Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх журамд заасан өдрүүдэд МУИС дээр зохион байгуулна. Элсэлтийн комиссын хаяг, элсэгчдийн материал хүлээж авах болон мэргэжил сонгуулах цагийн хуваарь, нэмэлт мэдээллийг тухай бүр МУИС-ийн төв байрны гадна болон www.num.edu.mn вэб-д байрлуулна
12. Бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
 - a. Бүртгэлийн анкет (тухайн үед тусгай маягтаар бүртгэнэ)
 - b. Эзэмшсэн боловсролын үнэмлэх, дипломын эх материал (нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт)
 - c. Иргэний үнэмлэхийн хуулбар (нотариатаар гэрчлүүлэх албагүй)

- d. Цээж зураг 2 хувь (тухайн оны)
- e. Бүртгэлийн хураамж

Дөрөв. Оюутан элсүүлэх шалгаруулалт

13. МУИС-ийн орой, эчнээ сургалтад элсэгчдийн тоог сургалт явуулах тусгай зөвшөөрлийн хяналтын тоог баримтлан жил бүр тогтооно
14. Шалгуулагчдыг өгсөн шалгалтын нийт оноогоор (энэхүү журмын 10-д заасан аргачлалаар тодорхойлсон) жагсааж, онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ
15. Хяналтын тоонд багтсан хүмүүст сургуулийн суралцах эрхийн бичиг олгоно.

Тав . Элсэгчдийг бүртгэх

16. Элссэн хүмүүс тухайн хичээлийн жилийн 8 дугаар сарын 25-30-нд МУИС дээр бүртгүүлнэ. Дурьдсан хугацаанд бүртгүүлээгүй хүнийг сургууль орхисонд тооцож хасна.
17. Элссэн хүмүүс бүртгүүлэхдээ дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:
 8. Урьд эзэмшсэн мэргэжлийн диплом буюу түүнтэй адилтгах бичиг баримт
 9. Иргэний үнэмлэх
 10. Цээж зураг 6 хувь
 11. Сургалтын төлбөр төлсөн баримт
 12. Эдгээр материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.
18. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн хүнийг МУИС-д элсүүлэхгүй, элссэн тохиолдолд хасна.
19. Энэхүү дүрэм нь МУИС-ийн захирлын тушаалаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

ХАВСРАЛТ 1

МУИС-ийн орой, эчнээ сургалтад элсүүлэх мэргэжил, шалгалт, нийт оноонд эзлэх харьцаа

Фак/ сур ^a	Мэргэжил	I - 70%	II - 30%
ГГФ	Оройн анги: Аялал жуулчлалын менежмент	Математик	Газар зүй
	Оройн анги: Геологи	Математик	Газар зүй
	Эчнээ анги: Цаг уур	Математик	Физик
МКС	Оройн анги: Мэдээллийн технологи	Математик	Англи хэл
ХЗС	Оройн анги: Эрх зүй	Эрх зүйн ерөнхий мэдлэг	
	Эчнээ анги: Эрх зүй		
ЭЗС	Оройн анги: Нягтлан бодох бүртгэл	Математик	
	Оройн анги: Санхүү	Математик	
	Эчнээ анги: Нягтлан бодох бүртгэл	Математик	
	Эчнээ анги: Статистик	Математик	
	Эчнээ анги: Хүн ам зүй	Математик	
ГХСС	Оройн анги: Англи хэлний багш	Англи хэл	

Тайлбар:

а) Факультет/сургуулийн бүтэн нэр :

ГГФ Газар зүй, геологийн факультет
 МКС Математик компьютерийн сургууль
 ХЗС Хууль зүйн сургууль

ЭЗС Эдийн засгийн сургууль
ГХСС Гадаад хэл, соёлын сургууль

